



Орхон аймгийн эрүүл мэндийн газар
Нийгмийн эрүүл мэндийн төв


2022 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН ОСОЛ ГЭМТЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ




Орхон аймаг
2022 он

ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН ӨВЧЛӨЛ 2022 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН БАЙДЛААР

Орхон аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар гэмтэл хордлого гадны шалтгаант 739 шинэ тохиолдол бүртгэгдэж, үүнээс 91 тохиолдол нас барсан байна. Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралт сүүлийн жилүүдтэй харьцуулахад өсөж буй үзүүлэлт ажиглагдаж байгаа ба тухайлбал осол гэмтлийн шалтгаант өвчлөл өмнөх оны мөн үеэс 2.6%-иар, нас баралт 2020 оны мөн үетэй харьцуулахад 44.4%-иар тус тус өссөн байна.



Нийт тохиолдлын 92.2% нь санамсаргүй байдлаар осол гэмтэлд өртсөн бол 7.8%-ийг санаатайгаар үйлдэгдсэн осол гэмтэл эзэлж байна.




Бүртгэгдсэн нийт тохиолдлыг хүйсээр авч үзвэл 516 нь эрэгтэй, 213 нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд энэ хугацаанд осол гэмтэлд өртсөн 10 хүн тутмын 7 нь эрэгтэйчүүд байна.


Эрэгтэй




Эмэгтэй



Осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн хамгийн их хувийг 30-34 насныхан эзэлж байна. Мөн 35-39 насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад тохиолдлын тоо өндөр байна.



Гэртээ байхдаа осол гэмтэлд өртөх тохиолдол хамгийн өндөр хувийг 36.1% /267/ эзэлдэг бол гудамж, зам талбайд осол гэмтэлд өртөх нь мөн адил 36.1%-тай байна.



ОСОЛ ГЭМТЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

/2022 оны эхний 11 сарын байдлаар/


Орхон аймгийн хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант өвчлөлийг уналтын шалтгаан 44.2%-р тэргүүлж байгаа бол 2-рт зам тээврийн осол 22.7%, 3-рт амьгүй механик хүчинд өртөх гэмтэл 14.6%, 4-рт хүчирхийлэл 7.4%, 5-рт түлэгдэлт 5.5%-ийг эзэлсэн байна.



Осол гэмтлийн шалтгаан тус бүрийг өмнөх онтой харьцуулан судлахад бүх төрлийн уналт, амьтай механик хүчинд өртөх, түлэгдэлт, хүчирхийлэл зэрэг шалтгаанууд өссөн үзүүлэлттэй байсан бол зам тээврийн осол /10.2%/ амьгүй механик хүчинд өртөх осол гэмтэл нь өмнөх оны мөн үеэс 23.9%-р буурсан үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн шалтгаан тус бүрд тохиолдлын тоо болон өссөн буурсан хувийг дараах хүснэгтээс харна уу.


Осол гэмтлийн шалтгаан	2021 (n=811)	2022 (n=830)	Өсөлтийн хувь
	Бодит тоогоор		
Санамсаргүй осол гэмтэл			
Зам тээврийн осол	187	168	-10.1
Бүх төрлийн уналт	291	327	12.3
Амьгүй механик хүчинд өртөх	142	108	-23.9
Амьтай механик хүчинд өртөх	17	32	88.2
Усанд живэлт	0	0	0
Амьсгал боогдох	1	0	-100
Түлэгдэлт	33	41	24.2
Хорт амьтан, ургамалд өртөх	1	1	
Санаатайгаар үйлдсэн осол гэмтэл			
Хүчирхийлэл	48	55	14.5
Амиа хорлох	0	3	

2022 оны эхний 11 сарын байдлаар осол гэмтлийн улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын 9.4% /70/ нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна. Энэ нь өмнөх оны нийт осол гэмтэлд эзлэх хувьтай харьцуулахад 0.2%-р буурч тохиолдлын тоогоор согтууруулах ундаа хэрэглэсэн байдал өмнөх оны мөн үеэс 22.2%-иар буурсан байна. Өөрөөр хэлбэл сард дунджаар 6 хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртөж байна.




ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


2022 оны эхний 11 сарын байдлаар гэмтэл, хордлого, гадны шалтгаант 91 нас баралт бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн буурсан үзүүлэлт байхгүй байна. Сард дунджаар 8 хүн осол гэмтлийн улмаас амь насаа алдаж байна.



Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 62 /68.1%/ нь санамсаргүй осол гэмтэлд өртсөн бол 27 /29.7%/ нь санаатайгаар амиа хорлох, санаатайгаар бусдад халдах буюу хүчирхийллийн улмаас амь насаа алдсан байна. Харин осол гэмтлийн улмаас амь насаа алдсан нийт тохиолдлын 2 /2.2%/ нь сэдэл тодорхойгүй байна.



Осол гэмтлийн шалтгаант нас баралт, хүйсээр



Осол гэмтлийн улмаас амь насаа алдсан нийт тохиолдлын 72 /79.1%/ нь буюу 10 тохиолдол тутмын 8 нь эрэгтэйчүүд байна.



Гэмтэл, хордлого, гадны шалтгаанаар нас барсан нийт тохиолдлыг санамсаргүй хордох, хорт бодист /эмийн болон эмийн бус бодис/ өртөх тохиолдол 37 /40.6%/-р тэргүүлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 9.7%-аар буурсан байна. Тэргүүлэх шалтгааны 2-рт амиа хорлолт 20.8%, Уналт 8.7%, Хүчирхийлэл 8.7%, зам тээврийн осол 5.4%-р нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд багтаж байна.

Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан



Шалтгаан тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад зам тээврийн осол 44.4%-иар уналтын шалтгаант нас баралт 20%-иар, мөн усанд живэлт, амьсгал боогдох, түлэгдэлт, хордолтын шалтгаант нас баралтууд тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин хүчирхийллийн шалтгаант нас баралт 60%-иар, байгалийн хүчинд өртөх 133%-иар, амиа хорлолт 58.3%-иар бүгд өссөн үзүүлэлттэй байгаа нь анхаарал татахуйц байна. Шалтгаан тус бүрээр бодит тоо болон өсөлтийн хувийг дараах хүснэгтээс харна уу.

Осол гэмтлийн шалтгаан	2021 эхний 11 сар	2022 эхний 11 сар	Өсөлтийн хувь
Бодит тоо			
Зам тээврийн осол	9	5	-44.4%
Уналт	10	8	-20.0%
Амьгүй механик хүчинд өртөх	1	1	0.0%
Усанд живэлт	3	2	-33.3%
Амьсгал боогдох	5	2	-60.0%
Түлэгдэлт	3	0	-100.0%
Хордолт	41	37	-9.8%
Байгалийн хүчинд өртөх	3	7	133.0%
Амиа хорлолт	12	19	58.3%
Хүчирхийлэл	5	8	60.0%
Тодорхойгүй	1	2	100.0%

Гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтыг насны бүлгээр авч үзэхэд 2022 оны эхний 11 сарын байдлаар 50-54 насанд нас баралт хамгийн өндөр үзүүлэлтийг эзэлж байна.

